


БАТЛАВ:  СУРГАЛТ,
ОЮУТАН ХАРИУЦСАН ДЭД ЗАХИРАЛ
Д-Р Д.БАДМААНЯМБУУ

МУИС-ийн 2020-2021 оны хичээлийн жилийн урлагийн

бага наадам хөтөлбөр, удирдамж

Зорилго: МУИС-ийн оюутан залуучуудын эв нэгдэл, хамт олонч байдал, багаар ажиллах чадвар, гоо зүйн мэдлэгийг дээшлүүлэх, амралт чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, шинэ уран бүтээлч залуусыг уран бүтээл туурвихад дэмжлэг үзүүлэх, шилдэг үзүүлбэрүүдийг нэгтгэн МУИС-ийн нэрэмжит уран бүтээлийн тоглолт зохион байгуулах.

Үр дүн, ач холбогдол: МУИС-ийн оюутан залуусын багаар ажиллах чадвар, оновчтой шийдэл, шинэлэг санаа, ёс зүйтэй оюутан байх, түүнчлэн урлагийн авьяас чадвараа нээн хөгжүүлэх зэрэг ач холбогдолтой. Урлагийн наадмыг зохион байгуулснаар:

- ✓ МУИС-ийн баяр ёслол, хурал уулзалт, нэгдсэн арга хэмжээнд оролцох, оюутны тоглолтыг гаргах
- ✓ Урлагийн төрөл бүрийн тэмцээн уралдаанд оролцох шилдэг оюутнуудыг шалгаруулах
- ✓ МУИС-ийн дэргэд байгуулагдсан хөгжмийн болон бүжгийн хамтлагуудыг чадварлаг шинэ гишүүдээр сэлбэх
- ✓ МУИС-ийн шинэ хамтлаг, уран бүтээлчдийг бий болгох
- ✓ МУИС-ийн урлаг зааланд бэлтгэл сургуулилт хийж уран бүтээлийн чанарыг нэмэгдүүлэх гэх мэт олон талын үр дүнтэй юм.


Зохион байгуулагчид:

- ✓ МУИС-ийн Оюутан, төгсөгчийн хэлтэс
- ✓ МУИСОХ, Оюутан Конгресс

Хөтөлбөр: Урлагийн наадам нь нийт 7 төрлөөр явагдана. Үүнд:

- ✓ Гоцлол дуу 3-5 мин
- ✓ Хамтлаг бүжиг (Цэнгээнт) 4-6мин

- ✓ Хөгжим /ардын урлаг болон бусад үзүүлбэрт орсон хөгжмийн үзүүлбэрийн төрөл давхцахгүй байх/ 3-5 мин
- ✓ Хамтлаг дуу 4-6 минут
- ✓ Язгуур урлаг 4-6 мин
- ✓ Хамтлаг бүжиг /чөлөөт/ 4-6мин
- ✓ Уран уншлага



Жич: Заасан хугацаанаас хэтрүүлэхгүй байхыг анхааруулья.

Нээлт: Салбар сургууль тус бүрийн урлагийн наадам хуваарийн дагуу хичээлийн 2-р байрны А зааланд 09:00 цагаас эхлэх

Нээлтийн үйл ажиллагаанд салбар сургуулийн захирал, сургалтын албаны дарга бусад холбогдох зочдыг урьж оролцуулах, хаалтын шагнал гардуулах үйл ажиллагаанд оролцуулах.

Хугацаа:

№	Салбар сургууль	Хугацаа	Хаана	Наадмын төрөл
1	Хүмүүнлэгийн ухааны салбар	2020.11.01	МУИС-ийн 2-р байр Урлаг заал	Урлагийн бага наадам
2	Бизнесийн сургууль	2020.11.07	МУИС-ийн 2-р байр Урлаг заал	Урлагийн бага наадам
3	Нийгмийн ухааны салбар	2020.11.08	МУИС-ийн 2-р байр Урлаг заал	Урлагийн бага наадам
4	Олон улсын харилцаа, нийтийн удирдлагын сургууль	2020.11.14	МУИС-ийн 2-р байр Урлаг заал	Урлагийн бага наадам
5	Байгалийн ухааны салбар	2020.11.21	МУИС-ийн 2-р байр Урлаг заал	Урлагийн бага наадам
6	Хэрэглээний шинжлэх ухаан инженерчлэлийн сургууль	2020.11.22	МУИС-ийн 2-р байр Урлаг заал	Урлагийн бага наадам
7	Хууль зүйн сургууль	2020.11.28	МУИС-ийн 2-р байр Урлаг заал	Урлагийн бага наадам

Шүүгчид: Салбар сургууль болгон 3 шүүгчтэй байх ба 2-5,5 гэсэн нарийвчлалаар шүүнэ. Шүүгчид мэргэжлийн дадлага туршлагатай байх.

Урлагийн наадамд оролцогчид:

- ✓ МУИС-ийн оюутан байх
- ✓ Салбар сургуулийн “Оюутны зөвлөл”-дөө оролцох төрөл үзүүлбэрээ урьдчилан мэдэгдэж бүртгүүлсэн байх
- ✓ Удирдамжид заасны дагуу хугацаа, хөгжим, хувцас тайзны жижиг хэрэгсэл бусад бэлтгэлээ урьдчилан хангасан байх
- ✓ Үзүүлбэр тодорхой, ойлгомжтой тоглолтын ерөнхий зохиомжид нийцсэн байх
- ✓ Урлагийн тоглолт үзүүлбэрийн үед шүүгчид, бусад оролцогчид, хамт олноо хүндэтгэн оролцох
- ✓ Нэмэлт микрофон, хөгжим хэрэгслээ бэлтгэж ирэх

Анхааруулга: Бүрэлдэхүүн сургуулийн оюутны зөвлөлийн дарга нар тухайн наадмын зохион байгуулалт чанарт анхаарч ажиллах ба урлаг заал /А заал/-ны эд хогшил, техник хэрэгслийн бүрэн бүтэн байдал, оролцогчдын сахилга бат зэрэгт онцгой анхаарч ажиллана уу?

Хянасан:



Оюутан, төгсөгчийн хэлтсийн дарга
Д-р М.Эрдэнэчимэг

Боловсруулсан:

Оюутан, төгсөгчийн хэлтсийн ахлах
мэргэжилтэн Л.Чинзориг